



**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2021 оны 03 сарын 09 өдөр

Дугаар 33


Даланзадгад сум

“Говь+Ус” хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 “ж”, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 2/4 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1. “Говь+Ус” хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.
2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө гарган, шаардагдах хөрөнгийг жил бүрийн аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж, үр дүнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /Р.Сэддорж/-д даалгасугай.
3. Байгаль орчны салбар, усны сав газрууд, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн хамтын оролцоонд тулгуурлан хөтөлбөрийг хэрэгжүүлж, үр дүнг тооцон жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулж ажиллахыг аймгийн Засаг дарга /Р.Сэддорж/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б. БАДРАА

462210138



“ГОВЬ+УС” ХӨТӨЛБӨР

/2020-2024/

Нэг. Ерөнхий мэдээлэл, үндэслэл

1.1. Өмнөговь аймгийн усны нөөц, ашиглалт хамгаалалтын өнөөгийн байдал

Өмнөговь аймаг нь Алтай өвөр говийн сав газар, Галба-Өөш, Долоодын говийн сав газар, Онги-Таац голын сав газар, Умард говийн гүвээт халхын дундад талын сав газар гэсэн 4 усны сав газарт хамаардаг бөгөөд Даланзадгад суманд Алтай өвөр говийн сав газрын захиргаа 2014 онд байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна. Онги-Таац голын сав газрын Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө 2014, Галба-Өөш, долоодын говийн сав газар, Алтай өвөр говийн сав газар, Умард гүвээт халхын дундад талын сав газруудын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө 2019 онд тус тус батлагдаж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Өмнөговь аймаг нь гадаргуугийн усан сүлжээ байхгүй усан хангамжийн эх үүсвэр нь газрын доорх усаар хангагддаг бүс нутаг юм. Бэлчээрийн болон хүн амын усан хангамжийн багаахан хэсгийг тус бүс нутагт орших булгийн усаар хангадаг. Тус аймгийн газрын доорх усны нөөц 261 сая м³/жил /Н.Жадамба 2007 он/ гэж тооцсон судалгаа байдаг бөгөөд 11 сумын 45 усны ордыг илрүүлэн ашиглалтын нөөцийг тогтоосон байдаг. Энэхүү 45 ордоос 3 томоохон ордыг уул уурхай ашиглалтын зориулалтаар ашиглаж байна.

Галба-Өөш, долоодын говийн сав газар, Алтай өвөр говийн сав газруудын нутаг дэвсгэрт стратегийн ач холбогдол бүхий томоохон ордууд болох Оюутолгой, Тавантолгой, Ухаа худаг, Нарийн сухайтын бүлэг орд Монголын алт, Саус говь сэндс, Өсөх зоос гэх мэт томоохон уул уухайн компаниуд газрын доорх усыг ашиглаж байна. Галба-Өөш, долоодын говийн сав газрын усны хэрэглээ сүүлийн жилүүдэд огцом өсөн нэмэгдэж Оюу толгой, Таван толгой, Ухаа худаг зэрэг ашигт малтмалын ордууд байрладаг бүс нутагт уул уурхайн эрчимтэй хөгжлийг дагалдан шинээр олон газарт хот суурин баригдаж, усны хэрэглээ өндөртэй үйлдвэр, аж ахуйн газрууд олширч байна. Үүнийг дагалдан газрын доорх усны нөөцөөс унд ахуй болон үйлдвэрийн зориулалтаар авч хэрэглэх хэмжээ ихээхэн өслөө. Мөн дэлхийн дулаарал, цаг уурын өөрчлөлтөөс хамааран ялангуяа энэхүү сав газарт газрын доорх тэжээгдэл буурч сүүлийн жилүүдэд олон тооны булаг шанд ширгэх худгуудын усны түвшин буурах үзүүлэлттэй байна.

Сүүлийн жилүүдэд сумын төвийн иргэдийг ая тухтай орчинд амьдрах нөхцөл боломжийг сайжруулах, стандарт шаардлага хангасан ундны усаар хангах зорилгоор сумын төвийн ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээг улсын болон орон нутгийн төсөв, гадаад зээл тусламжийн санхүүжилтээр барьж байгуулж байна. Аймгийн хэмжээнд төв суурингийн усан хангамжийг 37 усны эх үүсвэрээс 70 ус түгээх байраар дамжуулан 54917 хүн ам стандарт шаардлага хангагдсан усаар хэрэглээгээ хангаж байна. Манай аймгийн хувьд нийт нутаг дэвсгэрийн 61,3 хувь буюу 10,1 сая га бэлчээртэй, үүнийг 54.7 хувь усжуулагдсан. 6546 малчин өрхийн 2.8 сая толгой мал сүрэг бэлчээрийн 5000 худгаас жилийн 4 улиралд хэрэгцээгээ хангаж ирсэн. 2017 оны уст цэгийн тооллогоор худгийн тоо - 5153, гол-1 нуур-1, булаг - 419 тоологдсон.

Даланзадгад сумын төвийн усан хангамжийг 9 гүний худгаас 36 ус түгээх байраар дамжуулан хэрэглэгчдийг ундны усны стандарт хангасан усаар хангаж байна. 1000м³ багтаамжтай 3 ширхэг усан сантай. Дэлхийн банкны санхүүжилтээр усны чанарын судалгааг 2019 онд баруун сумдын усан хангамжийн эх үүсвэрт хийж тухайн судалгааг үндэслэн 2020 онд Гурвантэс, Сэврэй, Ноён, Баяндалай сумдад цэнгэгжүүлэх, халдваргүйжүүлэх тоног төхөөрөмжийг суурилуулж иргэд стандарт шаардлага хангасан ундны усаар хангагдаж байна. Баяндалай, Гурвантэс, Ханбогд, Ноён, Номгон, Цогтэций, Даланзадгад, Ханхонгор сумдын төвлөрсөн усан хангамжийн зориулалтаар ашиглах усны эх үүсвэрийн хайгуулын судалгааны ажлыг хийж гүйцэтгэн нөөцийг баталгаажуулан гадаад, дотоод тэжээгдлийн мужийг БОНАЖЯам тогтоож сумдын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоолоор хамгаалалтад авсан.

1.2. “Говь+Ус” хөтөлбөр боловсруулах үндэслэл, шаардлага

Эрдэмтдийн судалгаагаар газрын доорх ус 5000 жилд 1 удаа эргэлтэд орж нөхөн сэлбэгддэг байна. Иймээс говь нутгийн амин гол хүчин зүйл нь газрын доорх ус бөгөөд гадаргын усан сүлжээ байхгүй манай аймгийн хувьд өсөн нэмэгдэж буй ачааллын улмаас амин чухал нөөцийг зүй зохистой удирдах нь шийдвэрлэх асуудал болоод байна.

Хоёр. “Говь+Ус” хөтөлбөрийн зорилго, зорилт

2.1. Усны нөөцийн хомсдлоос сэргийлж, боломжит нөөцийг зүй зохистой ашиглах, гадаргын усыг хуримтлуулан, эрэлт хэрэгцээг хүртээмжтэй хангах нөхцөлийг бүрдүүлэн говийн бүс рүү ус дамжуулах хоолой барьж байгуулахыг бодлогоор дэмжиж, хүн ам, бэлчээр, уул уурхайн усан хангамжийг сайжруулахад хөтөлбөрийн зорилго оршино.

2.2. Хөтөлбөрийн зорилтыг доорх стратегийн зорилтуудаар дамжуулан хэрэгжүүлнэ.

2.2.1. Усны нөөцийг хамгаалан түүний бүрэлдэн тогтох, бохирдолгүй, байгалийн аясаар сэргэх боломжийг хангах.

2.2.2. Усны нөөцийн хуримтлалыг бий болгох, хүн амыг эрүүл ахуйн стандартын шаардлагад нийцсэн усаар хангаж, үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн ус хангамжийг сайжруулан тогтвортой ногоон хөгжлийг дэмжих нөхцөлийг бий болгох.

2.2.3. Усны хэмнэлт, усгүй технологи, зохистой хэрэглээг хэвшүүлэх, усны нөөц бохирдох, хомстохоос сэргийлэх, усыг хуримтлуулах, нөөцийг арвижуулахад чиглэсэн олон төрлийн дэвшилтэт арга технологийг нэвтрүүлэх боломжоор хангах.

2.2.4. Газрын байгалийн тогтоц, булаг шандны эх, хур тунадас, хайлсан цас, мөсний усыг хуримтлуулах хөв цөөрөм, далд усан сангууд байгуулж олон зориулалтаар ашиглах усан сан барих нөхцөлөөр хангах

2.2.5. Хаягдал ус дахин боловсруулах, цэвэршүүлэх дэвшилтэд техник, технологийг нэвтрүүлэх, цэвэршүүлсэн саарал усыг дахин ашиглах үйл ажиллагааг төлөвлөх, бодлого хэрэгжүүлнэ

2.2.6. Говийн бүсийн усны судалгаа, шинжилгээний төв байгуулах, усны салбарын мэргэжлийн боловсон хүчнийг чадавхижуулан, хүний нөөцийг нэмэгдүүлж, гадаад дотоодын сургалтанд хамруулах ажлыг бодлогоор дэмжих

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат.

3.1. Хөтөлбөрийг 2020-2024 онд хэрэгжүүлнэ

Дөрөв. “Говь+Ус” хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, арга хэмжээ

4.1. Говийн бүсийн уул уурхай, хүнд үйлдвэрийн усан хангамжийг сайжруулах зорилт

4.1.1 Хөх морьт төслийн хүрээнд гадаргын усны хуримтлал бий болгон усан хангамжийг нэмэгдүүлэх Орхон-Онги төслийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулан төслийн байгууламжийн ажлыг эхлүүлнэ.

4.1.2 Говийн бүс рүү ус дамжуулах хоолой барьж байгуулан, усны нөөцийг хамгаалж, ногоон хөгжлийг бий болгоно.

4.1.3 Усыг хуримтлуулах нөөцийг арвижуулахад чиглэсэн олон төрлийн дэвшилтэт арга технологийг нэвтрүүлнэ.

4.1.4 Газрын доорх усны хяналт шинжилгээний цэгийг өргөжүүлнэ.

4.1.5 Ус хэмнэлт усгүй технологи зохистой хэрэглээг хэвшүүлэн усны нөөц бохирдох, хомсдохоос сэргийлж хяналтыг сайжруулна

4.2. Говийн бүс нутгийн усны нөөцийг хамгаалах, түүний бүрэлдэн тогтох, цэвэр ариун чанараа хадгалах, байгалийн аясаар сэргэх, бүхий л боломжийг хангах зорилт

4.2.1. Усны нөөцийг бохирдол хомстолоос сэргийлэх нэгдсэн менежментийг хэрэгжүүлж, Даланзадгад сумын цэвэр усны хангамжийн асуудлыг бүрэн шийдвэрлэж цэвэрлэсэн болон саарал усыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах

4.2.2. Хүн амыг баталгаат ундны усаар хангах, усны эрэл хайгуул зураглалын ажлыг эрчимжүүлж, нөөц баялгийн мэдээллийн бааз суурийг өргөжүүлэх, төлөвлөлт менежмент хийх нөхцөлийг бүрдүүлэх

4.2.3. Гэр хороолол болон аялал жуулчлалын бүсэд “Эко жорлон” арга хэмжээг хэрэгжүүлж хөрсний болон газрын доорх усны бохирдлыг бууруулна.

4.3. Усны нөөц, сав газрыг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх гадаргын усыг хуримтлуулж хөв, цөөрөм байгуулах, булаг шандны эхийг хамгаалах усны нөөцийн зохистой менежментийн бодлого хэрэгжүүлж, ногоон бүс байгуулах санал санаачлагыг дэмжинэ.

4.3.1. Цэнгэг усны нөөц гол мөрний урсац бүрэлдэх эхийн 50 хувийг орон нутгийн тусгай хамгаалалтад авах

4.3.2. Усны нөөцийг хамгаалах, нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлж, үйлдвэрлэлийн зориулалттай усны хэрэгцээг бууруулж, үнэ цэнийг нэмэгдүүлэх, гадаргын усны хуримтлалыг бий болгох, усны нөөцийг бохирдол, хомстолоос хамгаалах, зохистой ашиглах, бэлчээрийг хамгаалах менежментийг хэрэгжүүлж, бэлчээр, усжуулалтын II аяныг өрнүүлж, бэлчээр усжуулалтыг 70 хувьд хүргэнэ.

4.3.3. Хөв цөөрөм, булаг шанд, урсацын тохируулгатай усан сан, ус нөөцлөх, дамжуулах, далд систем байгуулах ажлыг эрчимжүүлж усны хуримтлалыг нэмэгдүүлэх

Тав. “Говь+Ус” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим

5.1. “Говь+Ус” хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг, төлөвлөлт, удирдлага, байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийн зүй зохистой ашиглахад чиглэсэн бусад хөтөлбөрүүд, эдийн засаг, нийгэм, орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлттэй нягт уялдаатай харилцан зохицсон байдлаар хэрэгжүүлэх

5.2. “Говь+Ус” хөтөлбөрийн зорилго, стратегийн зорилт болон үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд иргэн, аж ахуй нэгж байгууллага, төр, иргэний нийгмийн оролцоог дэмжиж өргөнөөр оролцох, хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлэх

5.3. Говийн байгаль, цаг уурын онцлог, аж ахуй эрхлэх нөхцөл, хүн амын эрэлт хэрэгцээ, шаардлагыг хангасан байхад чиглэх.

Зургаа. “Говь+Ус” хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт

6.1. “Говь+Ус” хөтөлбөрийг хэрэгжилтийг аймгийн Засаг даргын Тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Сав газрууд хариуцна.

6.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг жил бүрийн аймгийн хөгжлийн төлөвлөгөөнд тусган, арга хэмжээг Засаг даргын Тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар холбогдох бусад талуудтай хамтран хэрэгжүүлж хэрэгжилтийг жил бүр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд танилцуулна.

6.3. Хөтөлбөрийн стратегийн зорилт, арга хэмжээг жил бүрийн аймгийн хөгжлийн төлөвлөгөө, төсөвт тусган хэрэгжүүлэхээс гадна санхүүжилтийг улсын болон орон нутгийн төсөв, олон улсын байгууллага, хандивлагч орны зээл, тусламж, Нэгдсэн үндэсний байгууллага, гадаад дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хөрөнгө оруулалт, хандив, тусламж, төслийн хөрөнгөөс давхардал, хийдэл, алдагдалгүй, хэмнэлт, үр ашигтай зохион байгуулах замаар хэрэгжүүлнэ.

Долоо. “Говь+Ус” хөтөлбөр хэрэгжүүлснээр гарах үр дүн

7.1. Говийн экосистем, хүн ардын ус хангамжийн эх үүсвэрийн аюулгүй байдлыг хангахад онцгой ач холбогдол бүхий гадаргын урсац бүрэлдэх эх болон ус хангамжийн эх үүсвэрүүдийг тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамруулан хамгаалах, ирээдүй хойчдоо хүлээлгэж өгөх баталгаа бий болно.

7.2. Усны нөөцийн менежментийн боловсронгуй тогтолцоо бүрдэж үйл ажиллагаа нь жигдэрнэ.

7.3. Аймгийн гэр хороолол болон орон сууцны айл өрхийг төвлөрсөн шугам сүлжээнд холбож, амьдрах нөхцөлийг нь сайжруулна.

7.4. Хөдөө, аж ахуйн үйлдвэрлэл хөгжиж, хүн амын хүнсний бүтээгдэхүүний хангамж сайжирна.

Найм. “Говь+Ус” хөтөлбөрийн хэрэгжилтийг хянах тогтолцоо, үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлт

8.1. “Говь+Ус” хөтөлбөрийн хэрэгжилтэд аймгийн Засаг даргын Тамгын газар, иргэний нийгмийн байгууллага хяналт тавьж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд жил бүр танилцуулна.

8.2. “Говь+Ус” хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт, шинжилгээ, үнэлгээг аймгийн Засаг даргын Тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Сав газрууд, Сумдын ЗДТГазар, Байгаль орчныг хамгаалах холбоо, төрийн бус байгууллага

болон бусад холбогдох байгууллага, аж ахуй нэгжүүдийн оролцоотойгоор нэгдсэн төлөвлөгөөний үндсэн дээр хийх бөгөөд шаардагдах зардлыг тухайн жилийн төсөвт тусган хэрэгжүүлнэ.

8.5. "Говь+Ус" хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан зорилт бүрийн хэрэгжилтийн үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийг стратегийн зорилт тус бүрээр урьдчилан тодорхойлсон байна. Үүнд:

8.5.а. Эрүүл ахуйн болон энгийн хамгаалалтад авсан ус хангамжийн эх үүсвэрүүдийн тоо болон талбай, эхийг нь хамгаалсан булаг, шанд, усны эх үүсвэрүүдийн тоо

8.5.б. Олон жилийн дунджаас нэмэгдсэн хур тунадасны хэмжээ, газар доорх усны хяналт-шинжилгээний цэгүүдийн нягтрал, мэдээллийн чанар, тасралтгүй байдал, тэдгээрээс авах мэдээллийн илтгэх чадварын өсөлт

8.5.в. Аймгийн хэмжээнд байгуулан ашиглаж байгаа хөв, цөөрмийн тоо, эрүүл ахуй, стандартын шаардлагад нийцсэн усаар хангагдсан хүн амын тоо, түүний өсөлт

8.5.г. Ариутгах татуургын хүртээмжийн өсөлт

8.5.д. Бохир ус цэвэрлэгээний түвшин, байгальд хаях бохирдуулагч бодис болон бохир усны хэмжээний бууралт

8.5.е. Усалгаатай газар тариалангийн талбай болон нэгж талбайгаас хурааж авах ургацын өсөлт

8.5.ё. Малын усалгааны цэгийн тооны өсөлт, бэлчээр ашиглалтын сайжралт, бэлчээр усжуулалтын хувь

8.5.ж. Усны салбарын боловсон хүчний хангамж, мэргэжлийн бэлтгэлийн дээшилсэн түвшин

8.5.з. Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулах усны хэмжээний бууралт (усны хэмнэлт) зэрэг байна.